



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/414

Булган сум

Нийлүүлэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны автомашины нийлүүлэгчээр шалгарсан "Цэ-Ус" ХХК-тай 289,340,000 (хоёр зуун наян есөн сая гурван зуун дөчин мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү)-т олгосугай.

2.Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч, данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (О.Наранжаргал)-д зөвлөсүгэй.

3.Гэрээнд заасан барааг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг "Цэ-Ус" ХХК-ийн гүйцэтгэх захирал (М.Хашмаргад)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус барааны санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010578

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 12-ны нийгдрийн
А/414 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

| д/д | Нөхцөл шаардлага | Мөнгөн дүн | Хариуцах албан тушаалтан |
|-----|------------------------|---|------------------------------|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Бараа нийүүлэх хугацаа | Гэрээнд зааснаар | Б.Одхүү |
| 2 | Баталгаат хугацаа | 12 сар | М.Хашмаргад О.Наранжаргал |
| 3 | Чанарын баталгаа | Гэрээнд зааснаар | Б.Ариунболд |
| 4 | Алданги | Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна. | Б.Ариунболд |